

**Үндэсний аудитын газрын харьяа
Ховд аймгийн аудитын газарт**


**2020 оны “Ховд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгууль” - д
бие даан нэр дэвшихээр горилогч Хашбаатарын Лхамсүрэнгийн мөрийн хөтөлбөр**

Иргэдийн итгэлийг алдалгүй бүрэн төлөөлнө

Бодлогын чиглэл 1. Хүндээ хөрөнгө оруулах

/Эрүүл, боловсролтой, зөв монгол хүн эх орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна/

- Иргэн бүрийг жилд дор хаяж нэг удаа эмнэлэгийн үзлэгт бүрэн хамруулах, шаардлагатай эмчилгээг нь хийлгэх санаачилга гаргаж ажил хэрэг болгоно.
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай нь хамтран үе шаттайгаар чанартай зохион байгуулах боломжыг бүрдүүлнэ.
- Сурагч бүрт суралцах эрмэлзлэл, зорилго бий болгох үүднээс шаталсан сургалтуудыг Ховд аймгийн багш нарын хамтаар тасралтгүй зохион байгуулна.
- Ховд аймгийн сурагчдыг гадаадын тэтгэлэгт шалгалтуудад үе шаттайгаар бэлтгэж, тэтгэлэгт хамруулах ажлыг санаачлан өрнүүлнэ.
- Залуучуудын бүтээлч санал, санаачилга бүрийг дэмжин, аймгийн тухайн асуудлыг хариуцсан байгууллагад нь хүргэж, боломжит дэмжлэгүүдийг авахад нь тусалж хамтран ажиллана.
- Эцэг, эхчүүдэд зориулсан “Инээмсэглэл дүүрэн ирээдүй” сургалтаа жил бүр зохион байгуулна.
- Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүд боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Ажил идэвхитэй хайж буй иргэн бүрийг сургалтын мэдээ, мэдээллээр бүрэн хангаж, сургалтуудад хамруулан, ажлын байр бий болгох санал санаачилгыг нь бүрэн дэмжиж ажиллана.
- Ховдын өрхийн жимсний аж ахуйн жишиг баг болгоно.
- Архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад төрлийн донтолт, хорт зуршлын хамааралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх тогтолцоог сайжруулах, сэтгэл зүйн



зөвлөгөө, тусламж, эмчилгээний үйлчилгээг хөгжүүлэх, олон нийтэд хүртээмжтэй, боловсронгуй болгоход анхаарч ажиллана.

Бодлогын чиглэл 2. Авилга, хүнд сурталгүй аймаг болох

/Иргэдийн төрдөө итгэх итгэлийг сэргээхэд албан байгууллагын удирдлагуудыг сонгох сонголт маш том нөлөөтэй/


- Иргэний танхимын ашиглалтыг сайжруулж, иргэдийн болон ТББ – уудын дуу хоолойг тогтмол сонсож, аймгийн бодлогод оруулдаг тогтолцоог бий болгоно.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй телевиз, радиод иргэд санал хүсэлтээ тогтмол илэрхийлж, санал бодлоо солилцох цагтай болно.
- Иргэд санал санаачилга болон гомдол маргаанаа илэрхийлж хариултаа холбогдох албаны ажилтан, удирдлагуудаас шууд авах боломжыг бүрдүүлнэ.
- Төрийн байгууллагуудын удирдлагуудыг сонгоход хамт олны болон иргэдийн саналыг тусгадаг болгох санаачилгын ажил өрнүүлж, хяналт тавьж, иргэдэд мэдээлнэ.

Бодлогын чиглэл 3. Иргэдэд ээлтэй санал санаачилга бүрийг дэмжиж, хамтран ажиллах

- Иргэдээ сонсож, тэдний гаргаж буй зөв санал санаачилга бүрийг ажил хэрэг болгож, аливаа асуудлыг урьдчилан харж зөв шийдвэр гаргаж чаддаг, иргэдийн төлөө чин сэтгэлтэй аймгийн удирдлагын багийг бий болгоход өөрийн оюун ухаан, хөдөлмөрөө бүрэн зориулж иргэн таны дуу хоолой болж ажиллана.



/Хашбаатарын Лхамсүрэн ПЮ89102015 - 99019765/



2020 оны 07 дугаар сарын 24

Ховд хот